



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.31 № 02/596  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНЫ  
ДАРГА Л.ТӨМӨРБААТАР  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Монгол Ардын намын хорооны Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (19 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Монгол Ардын намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 19 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



**МОНГОЛ  
АРДЫН НАМ**

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО  
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН РЕФОРМ

2024-2028 ОН

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ХӨВСГӨЛ АЙМАГ  
2024 он





Үндэслэл:

- ✓ Намын гишүүд дэмжигчдийн өдөрлөгөөс ирүүлсэн санал
- ✓ “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр
- ✓ “Хөгжсөн Хөвсгөл 2030” хөтөлбөр
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд Монгол Ардын Намаас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого бүсчилсэн хөгжлийн реформ” мөрийн хөтөлбөр
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

УРГА: АРД ТҮМНИЙ СОНГОЛТ

ЗОРИЛГО: ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРИЙН ХААЛГААР ОРУУЛНА.

**АГУУЛГА:**

**НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Боловсрол
- 1.3 Хүн ам, нийгмийн бүлгүүд рүү чиглэсэн хөгжлийн бодлого
- 1.4 Соёл, спорт

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ТОГТВОРТОЙ ХАНГАХ БОДЛОГО**

- 2.1. Хөдөлмөр эрхлэлт, шинэ ажлын байр, бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин
- 2.2. Боомтын сэргэлт, эрчим хүч, зам тээвэр
- 2.3. Дөрвөн улирлын аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл
- 2.4. Эрүүл хүнс
- 2.5. Хөдөө аж ахуй, Шинэ хоршоо хөдөлгөөн



## ГУРАВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

- 3.1. Хүний эрх
- 3.2. Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
- 3.3. Ухаалаг "E-Mongolia" AI шинэчлэл- Цахим засаглал
- 3.4. Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

### ДӨРӨВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

- 4.1. Уламжлалт нүүдлийн аж ахуй ба сорилт бэрхшээл
- 4.2. Ногоон эдийн засаг

### ТАВ. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1 Хойд бүсийн хөгжил
- 5.2 Мөрөн сумын хөгжлийн төлөвлөлт

### НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО


#### 1.1 Эрүүл мэнд

- 1.1.1. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэхэд иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгааны чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх "Нийгмийн эрүүл мэндийн төв"-ийг байгуулах, барилга, тоног төхөөрөмжийг үе шаттай шийдвэрлэнэ.
- 1.1.2. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах тогтолцоог орон нутгийн түвшинд зохион байгуулж, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.
- 1.1.3. Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг (теле медицин) өргөжүүлж, алслагдсан 10 эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлнэ.
- 1.1.4. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, "Эрүүл мэндийн аялал жуулчлал"-ыг бий болгоно.
- 1.1.5. Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангамжийг шийдвэрлэнэ. /Аймгийн Нэгдсэн эмнэлэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад биеийн тамир, сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах/
- 1.1.6. Анхан болон лавлагаа шатлалын эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг шинэчлэн, стандарт, чанарын



шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. /Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Алаг-Эрдэнэ, Хатгал сумдад бүрэн тоноглогдсон хэвтрийн үйлчлүүлэгч зөөвөрлөх автомашин, Хатгал суманд усан завь, бүх багийн эмч нарын мотоциклд парк шинэчлэл, нэн шаардлагатай багийг автомашинаар хангах, Эрүүл мэндийн газрын албан хаагчдын компьютер тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх, Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, Ханх, Хатгал Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагаан-Үүр, Жаргал сумын ЭМТ-ийн барилгыг бүрэн шинэчлэх, Төмөрбулаг, Алаг-Эрдэнэ, Рашаант, Баянзүрх сумын ЭМТ-ийн барилгыг өргөтгөх, Бүрэнтогтох сумын ЭМТ-ын их засвар, ЭМТ-үүдийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох/

- 1.1.7. Төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг бүсийн хэмжээнд өргөжүүлэх, аймгийн нэгдсэн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг төрөл зүйлийг нэмэгдүүлэх, хэвлийн мэс заслын дурангийн иж бүрэн аппарат, соронзон үелзүүрт томографи MRI, ангиографийн аппаратаар хангана.
- 1.1.8. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг шүдний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангаж “Эрүүл шүд- Хөвсгөл” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.1.9. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах, цахим хяналтын тогтолцоог бий болгох, хадгалалт, түгээлтэд тавигдах стандартын хэрэгжилтийг хангасан эмийн нэгдсэн агуулах барина.
- 1.1.10. Бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан, хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангах, бэлтгэх, тэдгээрийн эрүүл мэндэд онцгой анхаарах, аймгийн политехникийн коллежийг түшиглэн орон нутагт баклавар зэрэгтэй сувилагч бэлтгэнэ.
- 1.1.11. Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хөдөө орон нутагт эмч ажилчдын байр, хороолол, суурин бүсэд “Эмч ажилтны хотгон” байгуулах арга хэмжээ авна.
- 1.1.12. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.13. Аймаг, сум, хороо, баг бүрд иргэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ авах боломж бүхий “Эрүүл зөв амьдрал” жижиг төвүүд ажиллуулах боломжийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.
- 1.1.14. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлж,



аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгийн үйл ажиллагааг түшиглэн, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нэгж байгуулна.

- 1.1.15. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.

## 1.2 Боловсрол

**Сургалтын шинэчилсэн хөтөлбөрт суурилсан арга хэмжээг үр дүнд хүргэх зорилтын хүрээнд:**

- 1.2.1. “ОРОН НУТАГ СУДЛАЛ” хичээлийг чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүргэнэ. /Орон нутгийн ёс заншил, Орон нутгийн түүх, Орон нутгийн МАА, Орон нутгийн газар зүй/  
 1.2.2. Малчдын 4-5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг дэмжих “ЗУНЫ ЦОГЦ СУРГАЛТ” төслийг туршин хэрэгжүүлнэ.  
 1.2.3. “АХЛАХ СУРГУУЛЬ” хөтөлбөрийг цахим болон танхимын хэлбэрээр 6 бүсийн төв, Мөрөн суманд туршин хэрэгжүүлнэ.

**Хүүхэд хөгжил, хамгааллыг бодит байдалд суурилж хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

- 1.2.4. Хүүхэд бүрийн чадвар-хөгжлийн судалгаа төвтэй “ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ ХӨВСГӨЛИЙН ХҮҮХДҮҮД” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.  
 1.2.5. “ХҮҮХДИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГА”-ын нэгдсэн төвийг Мөрөн суманд байгуулна.  
 1.2.6. “ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ТӨВ”-ийг Хатгал тосгонд байгуулна.

**Багшийн хөгжил, нийгмийн баталгаа, үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

- 1.2.7. Мөрөн суманд “БАГШ ХОТХОН-ЦОГЦОЛБОР” төслийг хэрэгжүүлнэ.  
 1.2.8. Хүний нөөцийн бодлого, залуу боловсон хүчнийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.  
 1.2.9. “ТҮРЭЭСИЙН БАЙР-ЦОГЦОЛБОР” төслийг алслагдсан суманд эхний ээлжинд хэрэгжүүлнэ.  
 1.2.10. “АНГИ УДИРДАГЧ БАГШ” орон нутгийн урамшуулал-хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Суралцахуй төвтэй орчиныг бүрдүүлэх**

- 1.2.11. Эрүүл мэнд, биеийн тамир, спортын “ГАДНА ЦОГЦОЛБОР ТАЛБАЙ”-г сургууль, цэцэрлэг бүрийн орчинд шинэчлэн байгуулна.  
 1.2.12. Судалгаа, үнэлгээ, шалгалтын “ЦАХИМ ТАНХИМ”-ыг сургууль бүрт хөгжүүлнэ.  
 1.2.13. Суурин багуудад “ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ-ТӨВ”-ийг байгуулна.

## 1.3 Хүн ам, нийгмийн бүлгүүд рүү чиглэсэн хөгжлийн бодлого



0000000004

## Хүүхэд:

- 1.3.1 Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын үйлчилгээг сайжруулж сум бүрт гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын нийгмийн ажилтантай болгоно.
- 1.3.2 Хүүхдийн ордон, парк, зуслан, хөгжлийн төв, спортын талбай, хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээний тоо, орчин, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.3 Хүүхдийн бодит оролцоо, хэрэгцээнд суурилсан хөгжлийн үйлчилгээг дэмжинэ.
- 1.3.4 Эрсдэлт нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх арга хэмжээ авч, хариу үйлчилгээ, хяналтыг сайжруулна.
- 1.3.5 Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага шийдвэрлэлтийг нэмэгдүүлж, кейс үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулна.
- 1.3.6 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөл байдал тулгарсан үед авах арга хэмжээний мэдлэг, чадавхийг хүүхэд, өсвөр үеийнхэнд төлөвшүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.

## Гэр бүл:

- 1.3.7 Гэр бүлийн гишүүд, эцэг, эхчүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хандлага өөрчлөх, гэр бүлийн хөгжлийг дэмжих ажлыг салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд эрчимжүүлж, гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлнэ.
- 1.3.8 "Гэр бүлд зөвлөгөө өгөх танхим"-ыг сумдад байгуулж, бүх нийтийн соён гэгээрэл, гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээний орчин, нөхцөл, хамтын ажиллагааг сайжруулна.
- 1.3.9 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод чиглэсэн үйлчилгээ, орчин нөхцөлийг стандартад нийцүүлж, хамтарсан багийн ажлын үр нөлөөг дээшлүүлнэ.
- 1.3.10 "Хүүхэд хамгааллын бодлого" батлан хэрэгжүүлэх, эцэг, эхийн зөвлөл ажиллуулах, ажилтны гэр бүлийг дэмжих соёлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хэвшүүлнэ.
- 1.3.11 Хувь хүн, гэр бүлтэй ажиллагсдын хандлага, чадавхийг дэмжсэн арга хэмжээ авч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг анхан шатны нэгжид тогтвортой ажиллуулна.
- 1.3.12 Эхчүүдэд зориулсан төрөлжсөн мэргэжлийн асрах үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцүүлэн хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

## Бусад:

- 1.3.13 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.
- 1.3.14 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээхэд дэмжлэг үзүүлнэ.



0000000005



- 1.3.15 Зудад өртсөн малчдыг малжуулах хөтөлбөрийг эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж, малын тоо бус чанарыг чухалчилна.
- 1.3.16 Малчдын орлогын эх үүсвэртэй уялдуулж, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж НДШ-ийг сар бүр төлөхгүйгээр жилдээ багтаан төлөх, хувааж төлөх зохицуулалтыг шийдвэрлүүлнэ.
- 1.3.17 Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаална.
- 1.3.18 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.
- 1.3.19 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.20 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний жишиг төвийг дэмжинэ.
- 1.3.21 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг 2 дахин бууруулах бодлого баримтална.
- 1.3.22 “Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулан зуучлах үйлчилгээний тогтолцоог хөгжүүлнэ.
- 1.3.23 Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 1.3.24 Бага өртөлтэй түрээсийн орон байрны хангамжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.3.25 Зорилтот өрхүүдэд зориулсан түрээсийн орон байрны хөтөлбөр хэрэгжүүлнэ.

#### 1.4. Соёл, спорт


##### Соёл

1.4.1 Соёл урлагийн салбарын хүний нөөцийн чадавхуулж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар стандарт хангасан чанартай, хүртээмжтэй үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.4.2 “Соёл урлаг” хөтөлбөрийг баталж соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төсөл арга хэмжээг дэмжин хөгжүүлнэ.

1.4.3 Соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг олшируулж, гадаад дотоодын аялагчдад зориулсан хөтөлбөрүүдийг дэмжинэ.

##### Спорт



1.4.4. Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг дэмжих зорилгоор спорт залгүй сумд, Мөрөн сумын зарим багуудыг залтай болгож бүх нийтийг спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.5. Мөрөн суманд стандартын 6 замтай Фитнес төв бүхий усан бассейн шинээр барьж ашиглалтад оруулна.

1.4.6. Өсвөр үеийн шигшээ багийг бэлтгэх тогтолцоог сайжруулж 10-аас доошгүй төрлөөр хичээллүүлэх нөхцөлийг бүрдүүлэн спортын амжилтыг дэмжин ажиллана.

1.4.7. "Сорил-100 төв"-ийг зохион байгуулж Монгол хүний дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилтыг хангана.

1.4.8. Аймгийн төвд Спортын ордны барилгыг иж бүрэн засварлана.

1.4.9. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, дэд бүтцийг суурин газруудад бүтээн байгуулна.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ТОГТВОРТОЙ ХАНГАХ БОДЛОГО

### 2.1. Хөдөлмөр эрхлэлт, шинэ ажлын байр, бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин

#### Хөдөлмөр эрхлэлт, шинэ ажлын байр

- 2.1.1. Шинээр зохистой ажлын байр, өндөр технологийн шинэ ажлын байрыг бий болгох төлөвлөгөө баталж, ажилгүйдлийн түвшнийг тууштай бууруулах бодлого баримтлана.
- 2.1.2. "Ур чадвартай ажилтан" санаачилгын хүрээнд ажилтныхаа мэргэжлийн ур чадварыг ахиулах урт, богино хугацааны сургалтад хамруулсан ажил олгогчийг дэмжин ажиллана.
- 2.1.3. Урт хугацаанд ажил завсардсан болон эх орондоо буцаж ирсэн иргэдэд мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын зүгээс дахин ур чадвар эзэмшүүлэх, мэргэшлийн зэрэг, гэрчилгээ олгох үйл ажиллагааг дэмжинэ.
- 2.1.4. Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.1.5. Цагийн ажлын байрыг дэмжих, орон нутагт төлөвшүүлэх, бүртгэл мэдээллийн сан бий болгож ажил хайж буй иргэдэд нэг дороос үйлчилгээг хүргэж ажлын байранд зуучлах орчинг бүрдүүлэх /самшил/
- 2.1.6. "Старт-ап" гарааны бизнес эрхлэгчдийг орон нутгаас дэмжих, бизнес хөгжлийн төвд бизнесээ бойжуулах боломжийг бүрдүүлэх



Handwritten signature and official stamp with the number 0000000007.

- 2.1.7. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвийг бий болгож орчин нөхцөлийг бүрдүүлэх
- 2.1.8. Хувийн хэвшил, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих замаар шинэ ажлын байрыг бий болгох
- 2.1.9. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй болон бизнесээ эхэлж буй иргэдэд чиглэсэн зөвлөн туслах, ажлын байр нэмэгдүүлэх ахуйн үйлчилгээний төвийг аймгийн төв Мөрөн, хөдөөгийн сумдад нэмэгдүүлнэ.
- 2.1.10. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй хөдөлмөрийн насны иргэдийг түр болон цагийн ажлын байранд зуучлах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
- 2.1.11. Аялал жуулчлал, мал аж ахуйн чиглэлээр өрхийн үйлдвэр эрхлэгчдийг “Хөвсгөлд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүний төвлөрсөн цэг нээж орон нутгийн онцлогт нийцүүлэн үйлдвэрлэл хийж буй өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжих
- 2.1.12. Өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй хөдөлмөрийн насны иргэдийг жижиг дунд үйлдвэрлэл хөгжсөн аймаг, бусад орны туршлага судлуулах

#### Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин

- 2.1.13. Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд олгоно.
- 2.1.14. Зах зээл дэх чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, старт-апп компаниуд бойжих нөхцөлийг бүрдүүлж, залуучууд болон жижиг компаниуд шударгаар өрсөлдөх суурийг тавьж, аливаа нэг компани бүх салбарт давамгайл байдалтай ноёрхохгүй байх, нийтээр хөгжихөд дэмжинэ.
- 2.1.15. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ
- 2.1.16. Зээлийн уян хатан нөхцөлтэй тоног төхөөрөмжийг эрэлт хэрэгцээтэй уялдуулан нийлүүлнэ.
- 2.1.17. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд төвлөрлийг бууруулах зорилгоор Хөвсгөл аймагт шилжин ирсэн ажил олгогчдын дэмжих “Найрсаг Хөвсгөл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.1.18. Мөрөн сумын Гэгээ, Цагаан-Уул захууд орчмыг битүү зах болгож дэд бүтцийг шийдвэрлэж агаарын бохирдол, хотын өнгө үзэмж сайжруулах
- 2.1.19. Ахуй үйлчилгээгүй сумдад ахуй үйлчилгээний төвүүдийг бий болгож жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих
- 2.1.20. Аймгийн ЖДҮ хөгжүүлэх санг бий болгож жилд 1 тэрбумаас дээш төгрөгийг бага хүүтэй урт хугацаатай зээлийн бодлогоор дэмжих

#### 2.2. Дэд бүтэц



- 2.2.1. Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд “Сумын хөгжилд инженерийн дэд бүтцийн хангамж” төслийг хэрэгжүүлж сумдыг иж бүрэн төвлөрсөн инженерийн шугам сүлжээгээр хангана.
- 2.2.2. Босоо тэнхлэгийн аялал жуулчлалын хатуу хучилттай авто замыг шинээр барих (Архангайн Тариат- Хөвсгөлийн Жаргалант-Шинэ-Идэр- Мөрөн чиглэлд)
- 2.2.3. Олон улсын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Хөвсгөл нуурын зүүн эргээр дагасан 110 км хатуу хучилттай авто замыг шинээр барих (Ханх сумаас Хатгал тосгон хүртэлх чиглэлд)
- 2.2.4. Аймгийн төвийг алслагдсан сумдтай автозамаар холбох “Нутгийн зам” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.5. Аймаг, сум хоорондын шуудан хүргэлтийн үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртэлтийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлнэ.
- 2.2.6. Мөрөн сум доторх нийтийн тээвэр болон боловсон ая тухтай нийтийн тээврийн зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, алслагдсан багуудад нийтийн тээврийг хүртээмжтэй болгож, явах давтамжийг нэмэгдүүлэх
- 2.2.7. Хот хоорондын нийтийн тээврээр ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлж VIP үйлчилгээг нэвтрүүлж, зам дундын нийтийн бие засах газар, хоолны газар, засвар үйлчилгээний газруудыг стандартын дагуу барих ажлыг зохион байгуулах
- 2.2.8. Төр, хувийн хэвшлийн хамтарсан сум хоорондын нийтийн тээврийн нэгдсэн авто буудлыг барьж байгуулан тохижуулж ашиглалтад оруулах
- 2.2.9. Ачаа тээврийн нэгдсэн логистик төвийг аймгийн төвийн гадна талд байгуулах /ачаа тээврийн нэгдсэн логистик төв ашиглалтад орсноор бараа материалын эргэлт нэмэгдэх давуу талтай/

### 2.3. Дөрвөн улирлын аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл

- 2.3.1. “GoMongolia” арга хэмжээг үргэлжлүүлж, гадаад жуулчдын тоог жилд нэмэгдүүлнэ.
- 2.3.2. Аялал жуулчлалын агентлаг, аяллын операторын чиглэлээр нэн шаардлагатай хүчний нөөц мэргэжилтэн бэлтгэнэ.
- 2.3.3. Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.3.4. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худаг дааны сувгуудаар дэмжих бодлого баримтлана.
- 2.3.5. Аялал жуулчлалын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.3.6. Хилийн босмтын ажиллах хоног, цагийг уртасгаж нэвтрэх чадварыг сайжруулна.



2.3.7. Өвлийн саруудад зохион байгуулдаг арга хэмжээний тоог нэмэгдүүлнэ.

2.3.8. Аялал жуулчлалаар зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор, аялал жуулчлалын чөлөөт бүсийг байгуулна.

2.3.9. Онгоц нислэгийн тоог нэмэгдүүлж, аялал жуулчлалын голлох зам, амрах өртөө, түр отоглох цэгийг байгуулна.

2.3.10. Соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлж орон нутагт үлдэх өгөөжийг нэмэгдүүлнэ.

2.3.11. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

#### 2.4. Эрүүл хүнс

2.4.1. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлж, гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжинэ.

2.4.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.

2.4.3. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогын тогтвортой байдлыг хангана.

2.4.4. Өрх бүр тариаланч аян өрнүүлж, зуны нарлаг хүлэмжээр хангах бодлого баримтална.

2.4.5. Эко хүнс үйлдвэрлэгч болзол журам хангасан үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, эко хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл тоог өсгөж, зах зэлийн хүрээг нэмэгдүүлнэ.

2.4.6. Сум бүрт үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн орчин үеийн техник технологи бүхий мал нядалгааны цэгүүдийг бий болгоно.

2.4.7. Сумдын бяслагны үйлдвэрийг түшиглэн сүү цагаан идээний цехүүдийг бий болгоно.

#### 2.5. Хөдөө аж ахуй, Шинэ хоршоо хөдөлгөөн

##### Мал аж ахуй

2.5.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг аймаг, бүс нутгийн хэмжээнд өрнүүлж, иргэд хоршоолохыг дэмжинэ.

2.5.2. Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар хоршоог сумдад бий болгоно.



2.5.3 Эудын эрсдэлийг даван туулах “ӨВӨЛЖӨӨ” төсөл хэрэгжүүлж малын хашаа хороог сайжруулах зорилгоор малчид хөнгөлөлттэй нөхцөлөөр мод бэлтгэх боломж бүрдүүлэх

2.5.4. Еэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 45 худгийг шинээр гэрэж ашиглалтанд оруулна. /1 худгийг 35,0 сая.төг гэж тооцвол 1,6 тэрбум төгрөг/

2.5.5 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх шалгарсан арга аргачлалыг сурталчилж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дутагдалтай малын эмч, зоотехникч мэргэжилтэн бэлтгэх бодлого баримтална.

2.5.6. Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

2.5.7. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.5.9. Малчин өрхөд тэжээлийн ургамал, тариалах зорилгоор өвөлжөө, хаваржааны ойролцоох газрыг эргэлтэнд оруулж ашиглуулах /1 өрхөд 2 га хүртэл/

2.5.10. Сумдад малын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллана. /аймгийн нөөцөд жилд 300 тн өвс, 100 тн тэжээл/

2.5.11. Малыг чанарыг сайжруулахад дэвшилтэт технологи нэвтрүүлэн ашиглаж буй иргэдэд дэмжлэг үзүүлэх /жишээ нь: өндөр ашиг шимт үхрийн үрээр зохиомол хээлтүүлэг хийх/

2.5.12. Стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч бэлтгэн нийлүүлж буй мэргэжлийн байгууллагад дэмжлэг үзүүлэх /бух, хуц, ухна бэлтгэсэн мэргэжлийн байгууллагад/

2.5.13. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Мал амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хяналт, хариу арга хэмжээний бэлэн байдлын хангуулж ажиллах, төвтэй болох;


- Хашаа хорооны халдваргүйтгэлийг чанартай зохион байгуулж халдварт шимэгчдээс урьдчилан сэргийлэх;

2.5.14. Гоц халдварт өвчнөөр тайван бүс нутгаа баталгаажуулна.

2.5.15. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож эрсдэлийг даван туулах чадвартай мал аж ахуйг хөгжүүлнэ.

- Өсвөр малыг чиглэлтэй бойжуулж түргэн хугацаанд малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, туршил судалгаа хийж, түгээн дэлгэрүүлэх, гадаад дотоодын зах зээлд таатай нөхцөлийг бүрдүүлэх

- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг гарал үүслийг тодорхой болгох, малыг эзэмжүүлж, бүртгэл мэдээллийг нэгдсэн санд оруулах ажлыг эрчимжүүлэх



- Малын тэжээлийг нэмэгдүүлэх замаар ашиг шимийг улирлын хамаарлыг бууруулах

- Баталгаажсан үүлдэр омгийн малын ашиг шимийг тогтоож, мал аж ахуйн нэгдсэн санд бүртгэх, цаашид хамгаалах, ашиг шимийг нэмэгдүүлэх бодлоготой байх

- Баталгаажсан үүлдэр, омгийн малаар төрийн болон хувийн хэвшилд цөм сүргийг бүрдүүлж, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг бойжуулан, мэргэжилтний хяналтад доор малчин өрхөд түрээсээр ашиглуулах замаар нийт мал сүргийн чанарыг сайжруулах

#### Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

2.5.16. Хөдөө аж ахуйн салбарт туршилт судалгааны станцыг орон нутагт байгуулах

2.5.17. Төв суурин газрын хүн амыг хүнсний хэрэгцээг хангах зорилгоор сүүний үхрийн аж ахуйг стандартын дагуу байгуулж хөнгөлөлттэй зээл хүүгийн бодлогоор дэмжих

2.5.18. Ногоон тэжээл тариалах, хадлангийн талбайг малчин өрхөд эзэмшүүлэх

2.5.19. Газар тариалангийн бүсэд махны үхэр, хонины аж ахуйг дэмжих

2.5.20. Малчдад сургалт мэдээллийг үе шаттай зохион байгуулах, туршилт судалгааг хамтран зохион байгуулах

2.5.21. Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийг бий болгох, дэмжлэг үзүүлэх

2.5.22. Мал аж ахуйн дэвшилтэд технологийг ашиглаж, малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

2.5.23. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх зорилгоор бага оврын тоног төхөөрөмжөөр хангах бодлого баримталах

2.5.24. Малын гаралтай бүтээгдэхүүнийг үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх

2.5.25. Зөгийн аж ахуйг эрчимтэйгээр дэмжиж, зөгийн балын брэндийг бий болгох

2.5.26. Гарал үүсэл нь тодорхой Хөвсгөл-Органик ноос, хөөвөр, ноолууран бүтээгдэхүүн болон мах, сүүн бүтээгдэхүүний хөгжүүлэх, сурталчлах

2.5.27. Гадаад дотоодын жуулчдыг малчин өрхөөр зочлуулах арга хэмжээг зохион байгуулах, нүүдлийн соёл, бэлчээрийн мал аж ахуйг сурталчлах үүнээс орлого олох боломжийг бий болгох

2.5.28. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эвэнт үйл ажиллагааг жил бүр зохион байгуулах

2.5.29. Хариуцлагатай нүүдэлчин стандартыг нэвтрүүлэх замаар малыг тэжээлэг арчилгаа маллагааг сайжруулах



2.5.30. Малын хашаа хороог сэлбэх, шинээр барихад дэмжлэг үзүүлэх замаар малын тавлаг байдлыг хангах

2.5.31. Сум бүр отрын нөөц бэлчээртэй болох, нөөц бэлчээрт худаг ус гаргах

2.5.32. Тусгай хамгаалалттай газар отор нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх

2.5.33. Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг ашиглах худаг ус гаргах

2.5.34. Малын бүрэн найрлагат тэжээлийн үйлдвэрийг газар тариалангийн бүс нутгийг түшиглэн байгуулах

2.5.35. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх дэвшилтэд аргыг нэвтрүүлэх

2.5.36. Стандарттай мал аж ахуйг хөгжүүлсэн малчныг шагнаж, урамшуулах, хөнгөлөлттэй зээлд хамруулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх

2.5.37. Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулна.

2.5.38. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон салбар болгон хөгжүүлнэ.

2.5.39. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

#### Газар тариалан, хүнсний ногоо

2.5.40. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.

- Ашиглах боломж бүхий талбайн зам харилцааг сайжруулах /Бор бургас чиглэлийн зам/

- Тээлийн амны усалтын системийн засвар үйлчилгээг хийх /70 га талбай нэмэгдэх боломжтой./

2.5.41. Хөрс, цаг уурын онцлогт тохирсон дотоодын баталгаат сортын үрийн хангамж, тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.5.42. Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлж, "Атар IV" дүгээр аяныг хэрэгжүүлнэ.

2.5.43. ХАА-н техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ.

- Ногоон тэжээл тариалах, иж бүрэн техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ. /хадлангийн иж бүрдэл 50, 70, 80, 90 морины хүчин чадалтай иж бүрэн трактор/

- Байгалийн хадлан бэлтгэх техник тоног төхөөрөмжийн хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ. /20, 25-30 морины хүчин чадалтай иж бүрэн техник/





- Хүлэмж, жижиг талбайн хөрс боловсруулах шинэ техник технологийг нэвтрүүлнэ. /мотор блок, культиватор/

- Хөдөлмөр хөнгөвчилсөн шинэ технологи нэвтрүүлсэн төмс, ногоо хураах техник хэрэгсэл

2.5.44. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг газар тариаланг хөгжүүлнэ.

- Тосонцэнгэл сумын Тээлийн аманд дахь усалтын системг орчин үеийн тоног төхөөрөмжөөр шинэчилэн төмс, хүнсний ногооны тариалалтын нэмэгдүүлэх /60 га-аар/ мөн үерээс хамгаалах далан бий болгох
- Бүрэнтогтох сумын Эрчим багийн ногооны талбайруу татсан тогийг иргэн аж ахуйн нэгжийн талбайруу татаж хөдөлмөр, зардлыг хэмнэх
- Бүрэнтогтох сумын ногоон булгийн ногооны талбайруу явах замыг завсварлаж тариаланчдын гэзвэрлэх боломжийг бий болгох
- Тариалан суманд усалгаатай газар тариаланг бий болгох /Үр тариа 150 га/
- Мөрөн суманд дахь өвлийн хүлэмжийн цогцолборт 1000 м2 бүхий цогцолборыг нэмж бий болгож нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх
- Мөрөн суманд зүүчин чадал бүхий ногоо боловсруулах даршлах үйлдвэрийг байгуулах
- Шинэ хөдөө төсөлд түшиглэн техникийн дундын сервис үйлчилгээг үзүүлж механикжуулалтын түвшинг нэмэгдүүлэх

## **ГУРАВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ**

### **3.1. Хүний эрх**

3.1.1. Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.2. Цахим орчин дахь ялгаварлал, хүчирхийлэл, тэгш бус байдлыг бууруулж, хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

3.1.3. Төл иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.

3.1.4. Төрийн байгууллагын шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн аливаа шийдвэр гаргахгүй байхад анхаарна.

3.1.5. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгож, бүх түвшинд хүйсийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтална.

3.1.6. Заилшгүй шаардлагатай асуудлаар хяналт хийх “Нээлттэй сонгол”-ыг зохион байгуулж, иргэдийн мэдэх эрхийг хангана.

### **3.2. Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа**

3.2.1. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, бүх нийтийн шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулан танар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.2. Албан тушаалтны буруутай шийдвэрээс болж хохирсон төрийн албан хаагчийн хохирлыг буруутай этгээдээс барагдуулах ажиллагааг зохион байгуулна.



- 3.2.3. Сумдад дутагдалтай байгаа боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах бодлого хөтөлбөр хэрэгжүүлж, орон нутгийн нэмэгдлийг төсөвт нийцүүлэн 100 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.
- 3.2.4. Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 3.2.5. Төрийн албаны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх “Сургалт”, “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.2.6. Төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маг” сайн үнэлэгдсэн төрийн албан хаагчийг “1+2” буюу гадаадад хэлний бэлтгэл болон ахисан түвшний сургалтад хамруулах бодлого баримтална.
- 3.2.7. Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.8. Төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох, багш, эмч нарт зориулсан хотхон байгуулж, хөнгөлттэй үнээр орон сууц олгох бодлого баримтална.

### 3.3. Ухаалаг “E-Mongolia”-и шинэчлэл-Цахим засаглал

- 3.3.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, төрийн бүх үйлчилгээг цахимжуулснаар ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, хүнд суртал, авлигаас ангид аймаг болно.
- 3.3.2. Төрийн бүх үйлчилгээ цахим хэлбэрт шилжүүлж, “E-Mongolia” системийг хөгжүүлж төрийн үйлчилгээг шат дамжлагагүй хүргэнэ.
- 3.3.3. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулан шилэн ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 3.3.4. Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, газрын бүртгэл, харилцаанд “блокчейн” технологийг ашиглан маргааныг бууруулна.

### 3.4. Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

- 3.4.1. Төр иргэн хувийн хэвшил цахимаар мэдээлэл солилцох дэд бүтцийг сайжруулж, иргэд бизнест төвөггүй хялбар үйлчилгээг үзүүлнэ.
- 3.4.2. Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж, төр иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
- 3.4.3. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн хяналтыг сайжруулна.
- 3.4.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтыг бий болгож, 5 Ш ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 3.4.5. Олон нийтийн гудамж, зам, талбайн эрсдэлтэй газруудыг бүрэн камержуулах
- 3.4.6. Сум болгонд “ХУРДАН” төвийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх

ДӨРӨВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН



#### 4.1. Уламжлалт : үүдлийн аж ахуй ба сорилт бэрхшээл

- 4.1.1. Ус хөрс бэлчээрийг хамгаалах, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ авна.
- 4.1.2. Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг нэгтгэсэн стандартыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.
- 4.1.3. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах замаар ашиглагч-малчдыг хариуцлагажуулна.
- 4.1.4. Гэрээний дагуу даацаа хэтрүүлээгүй, зөв зохистой маллаж, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.
- 4.1.5. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 4.1.6. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.1.7. Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

#### 4.2. Ногоон эдийн засаг

- 4.2.1. Ногоон хөрөнгө оруулалт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламжийн удирдлага, бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Хог хаягдлыг бууруулах, байгалийн нөөцийг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, дахин боловсруулж, ашиглах санаачилгуудыг дэмжин байгальд ээлтэй техник технологийг нэвтрүүлж, ногоон бүтээгдэхүүн, тогтвортой хэрэглээ, амьдралын ногоон хэв маягт тулгуурласан "Тойрог" эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.3. Ногоон технологи, инновац, судалгаа шинжилгээ, гарааны бизнес, ногоон ажил эрхлэлтийг дэмжин, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.2.4. Ухаалаг, хэмнэлттэй хэрэглээ, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 4.2.5. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн өрөн сууц дэд бүтэцэд олгох ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.2.6. Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүтээмжийн хийн ялгарлыг бууруулна.
- 4.2.7. Хог хаягдлыг дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөгүй аргаар устгах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлнэ.
- 4.2.8. Ногоон хэрэглээг нэмэгдүүлэх бодит хөшүүргүүдийг үе шаттай бий болгож, төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад шилжүүлнэ.
- 4.2.9. Ногоон хөгжлийн шийдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боловсролын кампанит ажлыг хэрэгжүүлнэ.

#### **ТАВ. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**



## 5.1 Хойд бүсийн хөгжил

- Аж үйлдвэр, хүнд үйлдвэрлэл
- Шинжлэх ухаан технологи
- Байгаль, рашаан сувилал, хил орчмын аялал жуулчлал
- Эрчимжсэн хөдөө аж ахуй, газар тариалан

5.1.1 "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулж агад орон нутгийн аж ахуйн нэгжийг оролцоог дэмжинэ.

5.1.2 Бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

5.1.3 Хөвсгөл аймгийн Хатгал суманд "Хөвсгөл нуур, Дархадын хотгор, Цаатан ястны ахуй, түүх, соёлын дурсгалуудыг сурталчлах музейн цогцолбор байгуулна.

5.1.4. Мөрөн сумын нисэх онгоцны буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөнө.

5.1.5 Дээд боловсролын сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборыг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Орхон аймгийн хотхонд орон нутгийн оюутнуудыг сургах нөхцөлөөр хангана.

5.1.6 Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэх, Хөвсгөл аймгийн салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулж, Политехник коллежийн ангийг хойд бүсийн тэргүүлэх чиглэл, эрэлттэй ажил мэргэжлийн чиглэлд нийцүүлнэ.

5.1.7. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх тохиромжтой долоон байршлыг санал болгож, хүсэлт гаргасан хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

5.1.8. Мал амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай харилуурга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төвийг Хөвсгөл аймагт байгуулна.

5.1.9. Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр болох Зөгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.1.10. Ханх, Бага-Илэнх боомтын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.


5.1.11. Бүсчилсэн хөгжлийг дэмжих зорилгоор аймгийг төвийн ойролцоо "Сайжруулсан шахман гүлш"-ний үйлдвэр барьж, ашиглалтад оруулах

## 5.2 Мөрөн сумын хөгжлийн төлөвлөлт

5.2.1. Гэр хорооллын айл өрхийн 30 хүртэл хувийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох

5.2.2. Срон сууцны айл өрхийг халаалтын улиралд хэрэглээний халуун усаар хангах

5.2.3. Мөрөн суманд хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх



0000000017

- 5.2.4. Лэмцгэр Мөрөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх /хог ангилан ялгах, ландфил, шатаах зүүх/
- 5.2.5. Нийтийн тээврийн парк шинэчлэл хийж маршрутыг нэмэгдүүлэх
- 5.2.6. Дулааны станцын өргөтгөл, шинэчлэлийг хийх
- 5.2.7. Стор тууврын замын отоглох цэг, маршрутыг гарган ашиглах
- 5.2.8. Борооны ус зайлуулах суваг шуудууг сэргээх, сайжруулах

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

18

  
0000000018

14/10/2011 11:51:40